



ЗУУНМОД СУМЫН 5-Р СУРГУУЛИЙН

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх

Аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл:

jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Шинжээч

А.Батлхагва

Утас: 70273463 96011185

И-Мэйл: abatlhagva@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг: 2017 оны Здугаар сар 25

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Зуунмод сумын 5-р Сургуулийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-ТӨВ-2017/146/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Зуунмод сумын 5-р Сургуулийн урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай болон нийцлийн аудит 4200-р стандарт нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Зуунмод сумын 5-р Сургуулийн урсгал төсвийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн шинжээч А.Батлхагва хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Зуунмод сумын 5-р Сургуулийн 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дүгээр сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 25-нд Төв аймгийн Зуунмод сумын 5-р Сургуулийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн шууд захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын хууль гэх мэт хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Боловсролын тухай хуулийн 4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

5.1.Боловсролын үндсэн зарчим нь:

5.1.1.боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгана;

5.1.2.Монгол Улсад боловсрол нь хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх бөгөөд үндэсний болон хүн төрөлхтөний соёл иргэншлийн үнэт зүйлс, дэвшилт өв уламжлал, шинжлэх ухаанд тулгуурлана;

5.1.3.боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна;

5.1.4.иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана;

5.1.5.нийгэм, иргэний эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө бүхий, гадаад улсын санхүүжилт, зохион байгуулалттайгаар шашны чиглэлээр сургалт, шашны зан үйл, бусад үйл ажиллагаа сургалт зохион байгуулахыг хориглоно;

5.1.6.өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил тэгш хандана.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль”, “Боловсролын тухай хууль” “Сангийн сайдын” 2012 оны 276 дугаар тушаал “Төрийн сангийн” 2012 оны 205 дугаар тогтоол үйл ажиллагаатай холбогдсон хуулиуд бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Зуунмод сумын 5-р Сургуулийн урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Зуунмод сумын 5-р Сургуулийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 8 чиглэлээр 27 эрсдэлтэй асуудалд 27 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 42 хувь буюу 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд НББ-ийн бодлогын баримт бичгийг УСНББОУС, санхүүгийн бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм, журам зааварт нийцүүлэн боловсруулан батлуулж мөрдөж ажиллах гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Зуунмод сумын 5-р Сургуулийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 2015.01.20-ны өдрийн 7-р тушаалаар шинэчлсэн байна. Бүртгэлийн асcolous, Payroll програм ашигладаг байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг үнэлсэн тус байгууллага нь дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн шууд захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 708944.0 мянган төгрөг санхүүжилт, 157.4 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт, 6000.0 мянган төгрөгийн төслийн сургалтын тоног төхөөрөмж материалын санхүүжилт, 500.0 мянган төгрөгийн тэргүүний сургуулийн 1-р байрны шагнал, 350.0 мянган төгрөг дэлхийн зөнгөөс сургалтын төлбөр Отгонхүүгийн, 1492.5 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн орлого, 1621.8 мянган төгрөгийн сургуулийн багш нарын цалин, 45.0 мянган төгрөгийн шагналын орлого, буцсан гүйлгээ 496.0 мянган төгрөг, захиран зарцуулж төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 722055.9 мянган төгрөгийг зарцуулан тайлагнасан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос “shilendans.gov.mn” цахим сайтад зохих мэдээллийг оруулсан ба 2016 оны эхлэн цахим сайт өөрчлөлт сайжруулалт хийгдэж мэдээ мэдээллийг цаг тухай бүр нь сайтанд оруулан ажилласан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 8 чиглэлээр 27 эрсдэлтэй асуудалд 27 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 42 хувь буюу 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Зуунмод сумын 5-р Сургуулийн урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан горим сорил нь тус байгууллагын мөнгөн хөрөнгийн нийт зарлагын 100 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Шагналын зардлаас 5 ажилтан албан хаагчаас 11.5 мянган төгрөгийн ХХОАТ-г суутган авч тайлагнаагүй, Жижиг мөнгөн сангийн үлдэгдэл 0.4 мянган төгрөгийг тайланд тусгаагүй нийт 11.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн.

Энэ нь “Сангийн сайдын” 2012 оны 276 дугаар тушаалын 2.2-д “Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картын дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагтай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар /ЖМС/ дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно”. “Төсвийн тухай хуулийн” 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” 16.5.6-д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, “Боловсролын тухай хуулийн” 39.9-д “Боловсролд зориулсан төсвийн болон сангийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шагналын зардлаас суутгасан ХХОАТ 11.5 мянган төгрөг, жижиг мөнгөн сангийн үлдэгдэл 0.4 мянган төгрөг нийт 11.9 мянган төгрөгнд Төлбөрийн акт тогтоов.

2. Спорт заалны орлого 150.0 мянган төгрөгийг жижиг мөнгөн сангийн дансанд төвлөрүүлэн ахмадын баярын арга хэмжээнд төсвийн тооцоо судалгаагүй захиран зарцуулсан зөрчил илэрсэн. Энэ нь Монгол улсын “Боловсролын тухай хуулийн” 40 дүгээр зүйлийн 40.7-д “Суралцагчдаас хууль тогтоомжинд заагаагүй төлбөр хурамж авахыг хориглоно”. “Төсвийн тухай хуулийн” 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, “НББТухай хуулийн” 13.1-д “Анхан

шатны баримт нь нягтлан бодох бүртгэл, хөтлөх санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”. 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Спорт заалны орлого 150.0 мянган төгрөгийн жижиг мөнгөн сангийн дансанд төвлөрүүлэн ахмадын баярын арга хэмжээнд төсвийн тооцоо судалгаагүй хууль бус орлогонд төлбөрийн акт тогтоов.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Гэрээгээр ажилласан 2 ажилтан албан хаагчын цалингаас суутгасан НДШ 51.3 мянган төгрөг, ХХОАТ 37.5 мянган төгрөг нийт 88.8 мянган төгрөгийн авлага тайлагнасан алдаа зөрчил илэрсэн. Энэ нь Монгол улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн” 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл, хөтлөх санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”. 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх”, Төсвийн тухай хууль” 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтанд нь хяналт тавих”, 16.5.6-д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Шийдвэрлэсэн: Цалингаас суутгасан НДШ 51.3 мянган төгрөг, ХХОАТ 37.5 мянган төгрөг нийт 88.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар зөвлөмж хүргүүлэв.

2. Анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу 2768.7 мянган төгрөгийн гүйлгээг хийж тайлагнасан зөрчил илэрсэн.

Энэ нь Монгол улсын “НББТухай хуулийн” 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл, хөтлөх санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”. 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх. Төсвийн тухай хууль” 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд” 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтанд нь хяналт тавих” 16.5.6-д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг сайжруулахаар зөвлөмж хүргүүлэв.

3. Байгууллагын үндсэн хөрөнгийн тооллогыг шалгахад тооллогын комисс 1740797.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооцоог бодоогүй тайлагнасан алдаа .

Шийдвэрлэсэн: Байгууллагын эд хөрөнгийн тооцоог цаг хугацаандаа чанартай хийж байхаар тооллогын комиссын ажлын хэсэгт зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдсан алдаа байхгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Аудитын явцад залруулагдсан алдаа байхгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох шалгаж амжаагүй хөрөнгийн тооллого хийх асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Зуунмод сумын 5-р Сургуулийн урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 161,5 мянган төгрөг, материаллаг бус 1743655.3 мянган төгрөг нийт 1743816.8 мянган төгрөгийн 161.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд акт тогтоож аймгийн төсөвт төлүүлэхээр,

Үүнээс:

1. Материаллаг бус 1743655,3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөхөөр тус тус шийдвэрлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн аудитын газраас өмнөх оны санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгч байгууллагын удирдлагад 58.8 мянган төгрөгийн акт 3 зөвлөмж ,3 албан шаардлага өгснөөс акт албан шаардлага зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Зуунмод сумын 5-р Сургуулийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлээгүй тул Зөрчилгүй санал өгч байна.

Урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин 1444.1 мянган төгрөгнөөс материаллаг хэмжээний алдаа нь хэтрээгүй тул Зөрчилгүй санал өгч байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: ШИНЖЭЭЧ

О.АМАРЖАРГАЛ

А.БАТЛХАГВА